# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2009 оны 12 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 362 — Улаанбаатар хот

Журам батлах тухай

"Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл бэлтгэх журмыг 1 дүгээр, илтгэл хариуцан боловсруулах байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батaлсугай.

2. Илтгэл бэлтгэхтэй холбогдуулан тухайн байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, илтгэлийг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлж байхыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт даалгасугай.

3. Илтгэлийг боловсруулахад шаардагдах хөрөнгийг жил бүр төсвийн багцдаа тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, Авлигатай тэмцэх газар (Ч.Сангарагчаа)-т зөвлөсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын нэгдэж орсон Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн илтгэл бэлтгэх төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — С.БАТБОЛД

Гадаад харилцааны сайд — Г.ЗАНДАНШАТАР

Засгийн газрын 2009 оны 362 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛ БЭЛТГЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл бэлтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## Хоёр. Илтгэл бэлтгэх ажлыг зохион байгуулах

2.1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл хариуцан боловсруулах байгууллага батлагдсан хуваарийн дагуу бэлтгэх, "Үндэсний илтгэл хариуцан боловсруулах байгууллагын жагсаалт"-д ороогүй илтгэлийг тухайн конвенциор зохицуулж байгаа асуудал, салбарыг хариуцсан байгууллага бэлтгэх үүргийг хүлээнэ. Тухайн конвенциор хэд хэдэн салбарын асуудлыг зохицуулж байгаа тохиолдолд уг асуудлыг голлон хариуцах байгууллага илтгэл боловсруулах ажиллагаанд тэргүүлэх үүрэгтэйгээр оролцоно.

2.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл (цаашид "Илтгэл" гэх) бэлтгэх ажлыг тухайн илтгэлийг хариуцан боловсруулах байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг (цаашид "ажлын хэсэг" гэх) зохион байгуулна. Ажлын хэсэг нь тухайн илтгэлийг хариуцан боловсруулах байгууллагын удирдлагын шууд удирдлага дор үйл ажиллагаа явуулна.

2.3. Илтгэл бэлтгэхтэй холбогдон гарах аливаа зардал (бичиг хэрэг, албан ёсны орчуулга гэх мэт)-ыг тухайн байгууллагын төсвөөс гаргана. Илтгэл бэлтгэхэд олон улсын болон хандивлагч байгууллагаас санхүүгийн дэмжлэг авч болно.

2.4. Илтгэлийн төслийг бэлтгэхтэй холбогдуулан гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага бусад яам, газраас мэдээлэл, баримт материал, судалгаа гаргуулах буюу мэргэжлийн зөвлөгөө авч болно. Илтгэл бэлтгэхэд эрдэмтэд, мэргэжилтэн, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн бус байгууллагын саналыг аль болох авч, илтгэлд тусгах чиглэл баримтална.